



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/357

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ахмад багш нарын холбооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргаж аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

